

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДСЭН СУРГАЛТ ЯВАГДЛАА.

Эргэцүүлэлд суурилсан багшлахуй, сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх мэдлэг, ур чадвар, хичээлийн судалгааны арга зүйд дэмжлэг үзүүлэх зорилгоор 5, 10, 15, 20 дахь жилдээ ажиллаж буй багш нарын сургалт 2025 оны 04 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Сургалтад ерөнхий боловсролын 21 сургуулийн 113 багш хамрагдаж байна.

Танхимын үндсэн сургалтаар багш нар эргэцүүлэлд суурилсан багшлахуй болон суралцахуйн ур чадварыг хөгжүүлж, эргэцүүллийн 4 загварыг судалж, цахим орчинд сургалтын платформ, дижитал технологийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах, цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх, судалгаат хичээлийг ажиглах замаар хичээлийн судалгааны арга зүйн мэдлэг, ойлголт, ур чадвараа хөгжүүллээ.



Сургалт Арга зүйн хэлтсийн дарга Ж.Бумтуяа